


Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 5 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нууруудын сав газраар 6°C (32°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар +12.1°C (42.8°F) –аас +21°C (53.6°F), бусад нутгаар 6.1°C –аас +12°C (32°F –аас 41°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 5 дугаар сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 7.5 хувьтай тэнцдэг. Тус сард Архангай, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул болон Хөвсгөл, Төв, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 20-30 мм, Увс, Ховдын зарим хэсэг болон нутгийн өмнөд хэсгээр 2-10 мм бусад нутгаар 10.1-19 мм тунадас ордог байна.



**Зураг 1.** 1991-2020 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2026 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 0.4°C-аар, ОЖД-аас 0.8°C-аар дулаан байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 16 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн 43.4% нь дунджаас 1.0-ээс 3.0°C-аар дулаан, 56.6% нь дунджийн орчим байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 21.6 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 31.9%-иар, ОЖД-аас 60.1%-иар тус тус ахиу бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 5 дахь их тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 48.8% нь дунджаас ахиу, 44.2% нь бага, 7% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




**Зураг 2.** 2026 оны 5 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон дөрвөн бүсээр ангилан тооцоолсон 5 дугаар сарын хоногийн агаарын дундаж температурын явцыг авч үзэхэд (Зураг 3) нийт нутгаар 1 дүгээр 10 хоногоос 2 дугаар 10 хоногийн дунд үе хүртэлх ихэнхи хугацаанд ОЖД-аас 0.4°C-аас 11.4°C-аар дулаан байв. Харин 2 дугаар 10 хоногийн дундаас 3 дугаар 10 хоногийн дунд хүртэл ихэнх нутгаар агаарын температур ОЖД-аас -0.2°C-аас -7.1°C-аар хүйтэн байсан байна. Хур тунадасны хувьд ихэнх нутгаар ахиу хур тунадас орсон. Ялангуяа 2 дугаар 10 хоногт зүүн бүсийн нутгаар харьцангуй ахиу тунадастай байлаа.



**Зураг3.** Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Дорноговь аймгийн Хөвсгөл суманд 37.4°C, үнэмлэхүй бага утга Төв аймгийн Лүн суманд -9.5°C хүрч ажиглагдсан. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгор аймгийн Шинэжинст/Эхийнгол/ суманд 63°C, үнэмлэхүй бага утга Төв аймгийн Мөнгөнморьт суманд -12°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Увс аймгийн Малчин суманд 20-ны өдөр 51.4 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 951.0гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 760.4гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хамгийн их хурд Говь-Алтайн аймгийн Бугат суманд 36 м/с хүрсэн байна.



**Зураг 4.** Тус сард ажиглагдсан экстремаль утгууд